# МОНГОЛ УЛС
# ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 03 өдөр Дугаар А/277 Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан ард иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, эмнэлгийн тусламж үйлчилгээг хурдан шуурхай, чанартай хүргэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Сувилахуйн албаны дарга Д.Ариунаа, ахлах сувилагч Ж.Бумзаяа, хагалгааны сувилагч П.Эрдэнэбилэг, ээлжийн сувилагч Т.Гэрэлсүрэн, дурангийн сувилагч Ч.Доржпалам,туслах сувилагч Д.Чулуунцэцэг нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан Д.Ариунаа, Ж.Бумзаяа, П.Эрдэнэбилэг, Т.Гэрэлсүрэн, Ч.Доржпалам, Д.Чулуунцэцэг нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Улаанхүү/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.ДҮГЭРЖАВ

Zax A/277 Ch
02 01352